

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/257/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМАН ДАХЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮИЦЭТГЭЛД
ХИИСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, төрүүрдэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargals@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273405 Цахим хаяг: amalajargal@audit.gov.mn

Аудитын гэрээгээр гүйцэтгэгч: Голден Пэйж Аудит ХХК

Гүйцэтгэх захирал: С.Оюунгарал

Утас: 99170000 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open-audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41001 Төв аймаг, Зүүнмод сум
Утас: 7072962, Цэвэр нурууны тивийн газар
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.25 № 01/79

Тайлбар: _____

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМАН ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ш.ОТГОНХҮҮ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Боловсролын ерөнхий хууль шинэчлэгдэн батлагдаж үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан, уян хатан тогтвортой, нээлттэй, насан туршийн суралцахуйг дэмжсэн, ардчилсан хүмүүнлэг ёсыг дээдэлсэн сахисан байх, боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтлах тэргүүлэх салбар байна гэж зарчмаа тодорхойлсонтой нийцүүлэн байгууллагын нэр, дотоод дүрэмд нэмэлт өөрчлөлт хийлгүүлэн мөрдөн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний авч авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Төв аймгийн 6 сум, Хэнтий аймгийн 3 сум, Улаанбаатар, Багахангай, Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 118850 хөдөлмөрийн насны ажиллах

015073091

чадвар бүхий иргэдээс жилдээ 200-280 суралцагсдыг 13 мэргэжлээр элсүүлэн мэргэжил олгох сургалт олгож байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил мэргэжлийн баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, удирдах ажилтныг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах, холбогдох талуудын түншлэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөн гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

Гүйцэтгэлээр 9 үндсэн зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 12 ажил хугацаа болоогүй, 51 ажил хэрэгжиж гүйцэтгэл 89,7 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>65,564,536.74</u>	<u>157,539,869.74</u>
33	АВЛАГА	679,600.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	679,600.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,884,936.74	157,539,869.74
351	Түүхий эд материал	14,930,000.00	14,930,000.00
35110	Тусгай зориулалттай материал	14,930,000.00	14,930,000.00
354	Хангамжийн материал	31,654,936.74	125,389,869.74
35410	Бичиг хэргийн материал	983,090.00	2,455,430.00
35420	Аж ахуйн материал	14,395,152.00	18,641,852.00
35440	Түлш, шатах тослох материал	3,164,015.76	1,560,015.76
35450	Барилгын засварын материал	3,004,400.00	27,226,857.00
35460	Хүнсний материал	4,697,971.58	85,477.58
35470	Бусад хангамжийн материал	5,410,307.40	75,420,237.40
35600	Мал амьтад	18,300,000.00	17,220,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,633,757,369.08</u>	<u>1,742,749,958.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,633,757,369.08	<u>1,742,749,958.02</u>
392	Биет хөрөнгө	1,491,698,969.08	1,601,077,358.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,138,521,123.85	1,138,521,123.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(159,250,772.62)	(208,534,103.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,235,859.83	120,235,859.83
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,555,430.59)	(31,220,645.31)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	906,154,782.46	1,088,922,782.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(519,956,485.47)	(548,510,570.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,167,080.66	129,910,780.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105,796,129.74)	(112,996,309.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,330,000.00	1,330,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(830,000.00)	(879,999.98)
39217	Ном	21,678,940.70	24,298,440.70
393	Биет бус хөрөнгө	142,058,400.00	141,672,600.00
39301	Программ хангамж	19,733,000.00	19,733,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,646,600.00)	(17,032,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	162,128,000.00	162,128,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(23,156,000.00)	(23,156,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 111=1+11	<u>1,699,321,905.82</u>	<u>1,900,289,827.76</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,699,321,905.82</u>	<u>1,900,289,827.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,699,321,905.82	<u>1,900,289,827.76</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	464,952,792.60	464,952,792.60
51101	Өмч: -төрийн	464,952,792.60	464,952,792.60
512	Хуримтлагдсан үр дүн	24,922,573.90	225,890,495.84
51210	Өмнөх үеийн үр дүн	24,922,573.90	24,922,573.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	200,967,921.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,446,539.32	1,209,446,539.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН У1=1У+У	<u>1,699,321,905.82</u>	<u>1,900,289,827.76</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,761,537,353.79	2,031,946,584.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	468,245,053.79	208,435,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	468,245,053.79	208,435,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	468,245,053.79	208,435,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	767,699.73	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	467,477,354.06	208,435,300.00
120009	Бусад орлого	00.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,293,292,300.00	1,823,511,284.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,258,812,300.00	1,812,669,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,258,812,300.00	1,812,669,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,480,000.00	10,841,584.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,480,000.00	10,841,584.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,363,163,622.86	1,820,848,662.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,363,163,622.86	1,820,848,662.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,206,112,199.98	1,672,337,662.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	746,649,308.85	1,027,172,935.90
210101	Үндсэн цалин	491,979,851.00	593,910,575.26
210102	Нэмэгдэл	165,429,880.73	271,776,102.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,605,999.14	31,429,598.15
210104	Урамшуулал	57,633,577.98	130,056,659.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,306,300.00	129,606,000.00
210201	Тэтгэврийн даатгал	67,043,500.00	88,301,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,315,700.00	10,326,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,852,600.00	8,261,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,463,100.00	2,065,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,631,400.00	20,652,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,564,479.00	132,979,118.56
210301	Гэрэл, цахилгаан	35,459,794.00	58,487,718.56
210302	Түлш, халаалт	48,360,185.00	65,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,744,500.00	8,991,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,668,598.00	19,181,414.00
210401	Бичиг хэрэг	2,679,650.00	2,608,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,277,570.00	4,963,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,135,698.00	6,997,164.00
210404	Ном, хэвлэл	1,188,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,591,100.00	3,785,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,795,780.00	826,600.00
2105	Нормативт зардал	41,572,726.00	79,137,882.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	968,000.00	1,560,122.00
210502	Хоол, хүнс	39,426,426.00	76,354,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,178,300.00	1,222,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,598,300.00	69,665,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	441,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,032,600.00	11,421,870.00
210604	Урсгал засвар	8,565,700.00	57,802,920.00
2107	Томилолт, зочны зардал	1,836,000.00	3,260,300.00
210702	Дотоод албан томилолт	1,836,000.00	3,260,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,740,062.00	43,530,366.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,675,400.00	38,231,854.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	3,504,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,232,000.00	1,093,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,948.00	61,848.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	254,764.00	87,964.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,250.00	200,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	403,700.00	350,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,176,426.13	167,803,756.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,331,800.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,210,662.00	75,665,145.00
210903	үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,633,964.13	92,138,611.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,051,422.88	148,510,999.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,223,200.00	69,429,186.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,063,300.00	17,693,380.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,843,900.00	50,445,806.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,316,000.00	1,290,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,828,222.88	79,081,813.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,828,222.88	79,081,813.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	398,373,730.93	211,097,921.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,440,000.00	10,130,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,440,000.00	10,130,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,440,000.00)	(10,130,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	389,933,730.93	200,967,921.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,294,059,999.73	1,823,581,284.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	767,699.73	70,000.00
120	Нийтлэгтатварын бус орлого	767,699.73	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	767,699.73	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	767,699.73	00.00
120009	Бусад орлого	00.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,293,292,300.00	1,823,511,284.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,258,812,300.00	1,812,669,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,258,812,300.00	1,812,669,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,480,000.00	10,841,584.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,480,000.00	10,841,584.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,265,964,799.73	1,820,961,784.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,265,964,799.73	1,820,961,784.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,913,376.85	1,672,450,784.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	746,649,308.85	1,027,172,935.90
210101	Үндсэн цалин	491,979,851.00	593,910,575.26
210102	Нэмэгдэл	165,429,880.73	271,776,102.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,605,999.14	31,429,598.15
210104	Урамшуулал	57,633,577.98	130,056,659.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,306,300.00	129,606,000.00
210201	Тэтгэврийн даатгал	67,043,500.00	88,301,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,315,700.00	10,326,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,852,600.00	8,261,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,463,100.00	2,065,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,631,400.00	20,652,500.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,329,814.00	128,603,118.56
210301	Гэрэл, цахилгаан	35,459,794.00	58,487,718.56
210302	Түлш, халаалт	50,125,520.00	61,124,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,744,500.00	8,991,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,275,800.00	24,378,854.00
210401	Бичиг хэрэг	2,877,700.00	3,459,404.00
210402	Тээвэр, шатахуун	3,013,400.00	4,123,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,428,300.00	9,247,850.00
210404	Ном, хэвлэл	1,188,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.00	4,432,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,967,600.00	3,115,000.00
2105	Нормативт зардал	46,611,770.00	83,217,088.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	968,000.00	1,560,122.00
210502	Хоол, хүнс	41,527,770.00	75,140,466.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,116,000.00	6,516,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,398,700.00	78,541,067.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	900,000.00	1,424,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,928,000.00	15,118,070.00
210604	Урсгал засвар	8,570,700.00	61,998,097.00

2107	Томилолт, зочны зардал	1,836,000.00	3,260,300.00
210702	Дотоод албан томилолт	1,836,000.00	3,260,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,096,012.00	43,882,566.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,675,400.00	38,519,854.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	3,504,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,232,000.00	1,093,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,312.00	61,848.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	248,400.00	87,964.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	242,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	759,900.00	372,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,409,672.00	153,788,855.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,131,800.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,277,872.00	153,788,855.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,051,422.88	148,510,999.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,223,200.00	69,429,186.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,063,300.00	17,693,380.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,843,900.00	50,445,806.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,316,000.00	1,290,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,828,222.88	79,081,813.54
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,828,222.88	79,081,813.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,095,200.00	2,619,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,095,200.00	2,619,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,095,200.00	2,619,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,095,200.00	2,619,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,095,200.00	2,619,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(28,095,200.00)	(2,619,500.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,952,792.60	176,329,651.15	(217,022,596.42)	424,259,847.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	464,952,792.60	176,329,651.15	(217,022,596.42)	424,259,847.33
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(125,006,979.85)	(125,006,979.85)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,952,792.60	1,209,446,539.32	24,922,573.90	1,699,321,905.82
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,952,792.60	1,209,446,539.32	24,922,573.90	1,699,321,905.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	464,952,792.60	1,209,446,539.32	24,922,573.90	1,699,321,905.82
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	225,890,495.84	225,890,495.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,812,669,700.00	1,733,732,886.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,812,669,700.00	1,733,732,886.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,738,641,600.00	1,664,303,700.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,032,624,900.00	1,025,500,935.90
210101	Үндсэн цалин	579,381,000.00	593,910,575.26
210102	Нэмэгдэл	320,969,400.00	270,104,102.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,840,000.00	31,429,598.15
210104	Урамшуулал	104,434,500.00	130,056,659.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,078,000.00	129,078,000.00
210201	Тэтгэврийн даатгал	87,773,100.00	87,773,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,326,200.00	10,326,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,261,000.00	8,261,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,065,200.00	2,065,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,652,500.00	20,652,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,603,500.00	128,603,118.56
210301	Гэрэл, цахилгаан	54,791,500.00	58,487,718.56
210302	Түлш, халаалт	66,894,600.00	61,124,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,917,400.00	8,991,400.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,744,900.00	26,684,770.00
210401	Бичиг хэрэг	2,729,900.00	3,290,420.00
210402	Тээвэр, шатахуун	3,979,100.00	3,979,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,980,300.00	9,247,850.00
210404	Ном, хэвлэл	2,507,700.00	2,619,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,432,900.00	4,432,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,115,000.00	3,115,000.00
2105	Нормативт зардал	147,261,200.00	80,172,088.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,560,200.00	1,560,122.00
210502	Хоол, хүнс	139,184,500.00	72,095,466.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,516,500.00	6,516,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,333,100.00	75,333,067.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,424,900.00	1,424,900.00
210602	Гавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,118,100.00	15,118,070.00
210604	Урсгал засвар	58,790,100.00	58,790,097.00
2107	Томилолт, зочны зардал	3,260,300.00	3,260,300.00
210702	Дотоод албан томилолт	3,260,300.00	3,260,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,946,800.00	43,882,566.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,520,300.00	38,519,854.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,504,000.00	3,504,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,093,900.00	1,093,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,900.00	61,848.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	122,700.00	87,964.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,600.00	242,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	372,400.00	372,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151788900.00	151788855.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	151,788,900.00	151,788,855.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74028100.00	69429186.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,028,100.00	69,429,186.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,693,400.00	17,693,380.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	55,044,700.00	50,445,806.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,290,000.00	1,290,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,812,669,700.00	1,812,669,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,812,669,700.00	1,812,669,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,812,669,700.00	1,812,669,700.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	55	55
620001	Удирдах ажилтан	3	03
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33
620003	Үйлчлэх ажилтан	19	19

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,766,584.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,766,584.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,766,584.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,672,000.00
210102	Нэмэгдэл	1,672,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	528,000.00
210201	Тэтгэврийн даатгал	528,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	313,584.00
210401	Бичигхэрэг	168,984.00
210402	Тээвэр, шатахуун	144,600.00
2105	Нормативт зардал	3,045,000.00
210502	Хоол, хүнс	3,045,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,208,000.00
210604	Урсгал засвар	3,208,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10841584.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,841,584.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,841,584.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Анх Архуст дахь Улсын сангийн аж ахуйг түшиглэн Сургууль комбинат байгуулах тухай 1955 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Монгол Ардын Хувьсгалт Намын Төв хороо, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын сайд нарын зөвлөлийн 437/252 дугаар тогтоолоор байгуулагдсан. 1956-1981 онд нийт 6 мэргэжлээр 11908 суралцагчдыг төгсгөн тракторч, комбайнч, автын жолооч мэргэжлээр 20 хөдөлмөрийн баатар 8 гавьяат төрүүлжээ.

1981-1991 онд Техник мэргэжлийн сургууль болгон 3 төрлийн мэргэжлээр 3163 суралцагчдыг төгсгөн гаргажээ. 1991-2002 он хүртэл Мэргэжлийн Сургалт үйлдвэрлэлийн Төв болгон зохион байгуулагдан 9 мэргэжлээр 647 суралцагчдыг төгсгөн гаргасан байна.

2003 оноос Монгол Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоол, Засгийн газрын 34 дүгээр тогтоолоор Боловсрол Соёл шинжлэх ухааны сайдын 2033 оны 256 дугаар тушаалаар Эрдэнэ сумын ерөнхий боловсролын бүрэн дунд сургуультай нэгдэж үйл ажиллагаа явуулсан байна.

Засгийн газрын 2011 оны 218 дугаар тогтоолоор шинэчлэгдэн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болгон өөрчлөгдөн 2016 оноос байгууллагын чадавхыг дээшлүүлэх, сургалтын баазаа бэхжүүлэх, түншлэгч хамтран ажиллагч нартайгаа нягт харилцаа холбоотой ажиллаж, төсөл хөтөлбөрт хамрагдан, иргэдийн мэргэжил эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Байгууллагын үндсэн зорилт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, иргэний сонирхол, авьяас чадварыг харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хувь хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр мэргэжлийн боловсрол олгох, мэргэжлийн болон ур чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшсөн, эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц мэргэжлийн ур чадвартай ажилтан бэлтгэхэд оршино.

Сургалтад орчин үеийн шинэ техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, суралцагсдад үзүүлэх үйлчилгээг сайжруулж, сургалт үйлдвэрлэлийн материаллаг баазыг бий болгох, багш, алба хаагчдынхаа мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын сургалтын байгууллага, нийгмийн түншлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хамтран ажиллах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 6/01 тоот тушаалаар боловсролын сургалтын төвийн бүтэц орон тоог удирдах 3 ажилтан, гүйцэтгэх 38 ажилтан, үйлчлэх 19 ажилтан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжлийн боловсролын сургууль нь Боловсрол шинжлэх ухааны ерөнхий газрын харьяа Мэргэжлийн боловсрол олгох, сургалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж олон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21 -ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэ суман дахь Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” тэй байна. Мөрдөн ажилласан нэр зөв байсан

Эрдэнэ суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэ сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 303,886.5 мянган төгрөгөөр буюу 17,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	679.6		-679.6
Бараа материал	64,884.9	157,539.9	92,655.0
Үндсэн хөрөнгө	1,633,757.4	1,742,749.9	102,918.6
Нийт хөрөнгө	1,699,321.9	1,900,289.8	200,967.9
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,699,321.9	1,900,289.8	200,967.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,699,321.9	1,900,289.8	200,967.9

Хүснэгтээс харахад 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна.

- Авлагын үлдэгдэл өмнөх оноос 100 хувиар буурсан авлагыг барагдуулсан байна.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 142,8 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 64,884.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 383,856.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,483.2 мянган төгрөг нийт 394,389.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 301,734.5 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 157,539.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 12,9 хувиар өссөн байна. Үндсэн хөрөнгө данс нь 1,633,757.4 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд худалдан авсан 3,299.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй буюу хандиваар авсан 197,832.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмж бүртгэсэн байна. Нийт үндсэн хөрөнгө 108,992.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

- Өглөгийн талаар: Тайлант хугацааны эцэст өр төлбөр үүсээгүй байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 303,886.5 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлттөсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,777,056.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,777,056.3 мянган төгрөгөөр тооцон 2022 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 01/82 албан тоотой төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 587,989.3 мянган төгрөгөөр бууруулж, 1,189,067.0 мянган төгрөгөөр баталсан байгаа нь шалгагдагч байгууллагын хүргүүлсэн саналын үндэслэлийг харгалзан баталдаггүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 623,602.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн мэргэжлийн боловсрол 71804, хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал 80101, Ажил олгогчоос олгох тэтгэмж 80802, Дотуур байрны үйлчилгээ 81806 гэсэн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,812,659.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,733,732.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,733,732.9 мянган төгрөг буюу 95,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны нэмэгдэл цалин, норматив зардал, бусад урсгал шилжүүлэг бусад зардлуудаас 78,936.8 мянган төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Сургалтын үйлчилгээ -71804	1,812,669.7	1,733,732.8	78,936.8	95.6
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал - 80101	1,591,380.4	1,584,131.6	7,248.8	95.7
1.2	Ажил олгогчоос олгох тэтгэмж - 80802	74,028.1	69,429.1	4,598.9	93.8
1.3	Дотуур байрны үйлчилгээ-81806	147,261.2	80,172.1	67,089.1	54.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр 10,841.6 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин хөлс, норматив зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд олгосон байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төв аймаг Эрдэнэ суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн хэрэгжиж буй төсөл хөтөлбөр 95,6 хувиар хэрэгжсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулан үнийн харьцуулалт хийж, ханган хууль журмыг хэрэгжүүлэн ажилласан байна. Гол зардал нь хоол үйлдвэрлэл, засварын зардал гарсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 128,603.1 мянган төгрөг .хангамжийн зардал 24,378.8 мянган төгрөг,хоол хүнсний зардал 83,217.1 мянган төгрөг урсгал зардалд 61,998.1 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден Пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Дашням, Шинжээч Ц.Цацрал, Б.Ариунтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитор гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитор Ц.Саранчимэг, чанарын хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэ суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,761,537.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 26,423.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 18,496.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, төвийн захирал албан томилолтоор ажилласан зардлаа авахгүй байх зэргээр зардлыг 11,847.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор \ллм.3Ы1епс1ап5.до7.тп цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Мэргэжлийн боловсролын сургуулийн нь шилэн дансанд 2023 онд нийт 157 мэдээллийг хугацаанд нь байршуулж хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл байхгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр хөрөнгийн хэмжээ 839,750.1 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 2,003,208.4 мянган төгрөг, Засгийн газрын оролцоо 835,746.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх” гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Тооцооллын алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

4.4.2.2 Байгууллагын 546 нэр төрлийн 1,648,374.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс 438 нэр төрлийн 574,931.2 мянган төгрөгийн мянган хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн. Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн жагсаалт, хөрөнгийн мэдээллийг тодруулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь СТОУС-13 Бодит үнэ цэний хэмжилт стандартыг мөрдөн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллого тооцоог үр дүнтэй хийх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг өмч хамгаалах комисс болон бусад холбогдох газарт цаг тухай бүр гарган өгч шийдвэрлүүлж байх зөвлөмж өгөв.

4.4.2.3 Төв аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс 15 хоногийн хугацаанд 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн байна. Хяналт шалгалтаар Улсын байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 33-07-135 тоот актаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөхгүй” гэсэн заалтуудыг үндэслэн илүү нөөцөлсөн нүүрсний үнэ 3,164.0 мянган төгрөгийн төлбөрүүдийг төсөвт төлөхөөр акт тогтоосныг төсвөөс төлсөн байна. Энэ нь нүүрсний нөөцийг сар бүрийн орлого зарлагын гүйлгээ нөөцлөх хэмжээнд хүрээгүй, хэвийн хэмжээнд байгаа, хэвийн хэмжээнээс хэтрээгүй байхад үнэн зөв бодитой тодорхойлж чадаагүй, норм норматив зөрчөөгүй байхад үйл ажиллагаагаа хэвийн явуулах анхдагч хэрэгцээ болсон нүүрсний үнийг актаар төлүүлжээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг тогтоохдоо төсвийн захирагчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх, тал бүрээс нь бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хандаж шийдвэрлэдэг байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайланд илрүүлсэн 3,433.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 12,573.2 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	3,433.6		3,433.6	100
Зөвлөмж	2	12,573.2	2	12,573.2	100

/мянган төгрөгөөр/

Нийт дүн		16,006.8		16,006.8	
----------	--	----------	--	----------	--

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дотуур байрны 3 давхар барилга МСҮТ-ийн эзэмшлийн газар дээр баригдсан, эзэмшилд нь бүртгэлгүй, ЕБС-ийн хөрөнгөнд бүртгэлтэй. Хөрөнгө эзэмших эрхийг дээд газраар шийдвэрлүүлэх, Төрийн өмчийн хорооны 2013 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 13 тоот хуралдааны тэмдэглэлээр шийдвэрлэсэн орон нутгийн өмчид бүртгэлтэй, оюутны 3 давхар барилга, уурын зуухны барилга, агуулахын барилгыг төрийн өмчид хүлээж авах асуудлыг үзэх

Засгийн газрын тогтоолоор Төв аймгийн Эрдэнэ суман дахь мэргэжлийн боловсролын сургууль нэртэй болсон өөрчлөлтийг дүрмээр тодорхойлон баталгаажуулсан, тусгай зөвшөөрөл, газрын эрх зөвшөөрлийн өөрчлөлтийг бүртгүүлээгүй, хөдөлмөрийн дотоод журам шинэчлээгүй асуудлыг авч үзэхээр байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,820.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан алдаа байхгүй, 22,820.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Цалин хөлстэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт. Цалингийн тооцооны хүснэгтээр олгохоор тооцсон цалин 1,025,500.9 мянган төгрөг, нийгмийн даатгалд тайлагнасан дүн 1,024,853.6 мянган төгрөг, 647.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу

Үйл явдал үлдэгдэл нь тооцооллын алдаагүй.зөв хураангуйлж бүртгэдэг байх гэсэнтэй нийцээгүй
Өгсөн зөвлөмж: Тооцооллыг алдаагүй, үнэн зөв бүртгэдэг байх

1.2 Илрүүлэлт: Ажиллагсдын цалин хөлснөөс үйлдвэрчний эвлэлийн татвар 4,580.1 мянган төгрөг суутгасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-д "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг байх гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Өөрийн чиг үүрэгт хамаарахгүй ажил, үйлчилгээг гүйцэтгэхгүй байх зөвлөмж хүргүүлэв.

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотуур байрны зориулалтай 3 давхар барилга мэргэжлийн боловсролын сургуулийн эзэмшлийн газар дээр баригдсан, эзэмшилд нь бүртгэлгүй, ЕБС-ийн хөрөнгөнд бүртгэлтэй, өөрийн эзэмшлийн эрх шийдвэрлэгдээгүй, хөрөнгөнд 17,593.5 мянган төгрөгийн урсгал засварын зардал гарган уг барилгыг дотуур байрны зориулалтаар ашиглаж байгаа талаар зохих тодруулгыг бэлтгээгүй нь иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Хөрөнгө эзэмших эрхийн асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлсийг Нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй	1	647.3									1	647.3
Ү.Э-ийн татварыг ажилдагсдын цалингаас суутгасан	1	4,580.1									1	4,580.1
Урсгал засварын зардал	1	17,593.5									1	17,593.5
Дүн	3	22,820.9									3	22,820.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Улсын бүртгэлийн гэрчилгээ	1	835,746,951.6					1	835,746,951.6
Үндсэн хөрөнгийн талаар	1	574,931.3					1	574,931.3
Үндсэн үйл ажиллагааны зардал	1				1			
Ахмадын сан байгуулах	1				1			
Дүн	4	836,321,892.9			2		2	836,321,892.9
Нийт дүн	7	836,344,703.9			2		5	836,344,713.8

